



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 12 сарын 08 өдөр

Дугаар А/63.

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудлын үйл ажиллагаа
эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах тухай

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.1-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай сунгасугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан иргэн, аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.

3. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан иргэн, аж ахуйн нэгжүүдийн дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай сунгасугай.

4. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг мэргэжилтэн /С.Туул/-д үүрэг болгосугай.


5. Зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д даалгасугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2014 оны 12 сарын 08
№163 тоот тушаалын нэгдүгээр хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ
СУНГАХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН
ЖАГСААЛТ


2014.12.08

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Доун ХХК	Романсе	Багануур дүүрэг, 3-р хороо Нацагдоржийн гудамж
2	Рич холдинг ХХК	Рич	Баянгол дүүрэг, 22-р хороо, Зүүн Нарангийн 18/49
3	Улаанбаатар төмөр замын аялал жуулчлалын товчоо	Ган зам	Баянгол дүүрэг, 3-р хороо, Ган зам зочид буудлын байр
4	Ирмүүн дэлгэрэх ХХК	Хэрлэн	Багануур дүүрэг, 1-р хороо Нацагдоржийн гудамж 23 а
5	Ашид суврага ХХК	Ашид-Эрдэнэ	Баянгол дүүрэг, 14-р хороо, Ц.Хасбаатарын гудамж 18/16
6	Нью глори ХХК	Глори	Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, үйлдвэрийн 170-76-32

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2014 оны 12 сарын 08 өдрийн
А/63 тоот тушаалын хоёрдугаар хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ
ОЛГОХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН
ЖАГСААЛТ


2014.12.08

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Би Би Эйч Эч ХХК	Ивээл	Сонгинохайрхан дүүрэг, 13-р хороо, 1-р хороолол 198/1
2	Иргэн Я.Цэрэннадмид	Аз	Сонгинохайрхан дүүрэг, 15-р хороо, Өнөр хорооллын 65 а байрны хойно
3	Ногоон туяа ХХК	Ногоон туяа	Сонгинохайрхан дүүрэг, 27-р хороо, Толгойт-10
4	Баянцогт сонор ХХК	Сонор	Сүхбаатар дүүрэг, 9-р хороо, Алтайн12/352
5	Их баян нуур ХХК	Өнөр	Сонгинохайрхан дүүрэг, 13-р хороо, Өнөр хорооллын 65 а байрны хойно

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2014 оны 12 сарын 08 өдрийн
А/3 тоот тушаалын гуравдугаар хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ
СУНГАХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН
ЖАГСААЛТ

2014.12.08

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Иргэн Ц.Уранбилэг	Буудай	Баянзүрх дүүрэг, 7-р хороо, Доржийн гудамж 2/3
2	Зуно ХХК	Генерал	Баянзүрх дүүрэг, 16-р хороо, Дандарын гудамж 20
3	Касио ХХК	Ану	Сонгинохайрхан дүүрэг, 27-р хороо, Толгойтын гудамж 22
4	Иргэн Д.Сэдбазар	Наран мандал	Хан-Уул дүүрэг, 1-р хороо, Дунд голын гудамж 39/2
5	Ганзүмбэр ББН	Ганзүмбэр	Баянгол дүүрэг, 4-р хороо, 54-р байрны баруун талд

-ooOoo-